










ГЭРЭЭНД САНАЛ АВАХ ХУУДАС

“ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ХХК

Гэрээний дугаар	Гэрээ байгуулсан он, сар, өдөр	Гэрээ дуусгавар болох он, сар, өдөр
№40/2020	2020.09.17	2020.11.01
ГЭРЭЭНИЙ НЭР	ХУДАЛДАХ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ	
ТОВЧ УТГА	<p>АЙ ТИ ЗОН ХХК                  “Сүлжээний тоног төхөөрөмж, лиценз худалдан авах /Багц-2/: Багц-2                  Сүлжээний хамгаалалтын CiscoFirePower 2120 security appliance                  түүнтэй дүйцэхүйц, түүний лиценз худалдан авах</p>	
САНАЛ ӨГСӨН	Гүйцэтгэх захирал  Г.Балжинням	
	Тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий диспетчер  Б.Баатар	
	АСЭ дэд захирал  С.Бүрэнтогтох	
	ХЯНАСАН: Захиргаа удирдлагын албаны дарга  Б.Биндэрьяа	
	Санхүүгийн удирдлага, арилжааны албаны дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч  А.Цагаансар	
	Инноваци мэдээлэл технологийн албаны дарга  Б.Давааням	
	Захиргаа удирдлагын албаны худалдан авалт хариуцсан мэргэжилтэн  /Э.Өлзиймандах/	
БОЛОВСРУУЛСАН	Ахлах мэргэжилтэн  С.Намчиндорж	

БАТЛАВ: ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ  
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

БАТЛАВ: АЙ ТИ ЗОН ХХК-ИЙН ТЭРГҮҮН  
ДЭД ЗАХИРАЛ

/Г.БАЛЖИННЯМ/

/Б.ЦЭЭСҮРЭН/

**ХУДАЛДАХ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ**

2020 оны 09-р сарын \_\_\_-ны өдөр

№40/2020

Улаанбаатар хот

12/242-20-275


Нэг талаас Диспетчерийн үндэсний төв /ДҮТ/ ХХК /цаашид "Захиалагч" гэх/, түүнийг төлөөлж Инноваци мэдээлэл технологийн албаны дарга Б.Давааням, нөгөө талаас Ай Ти Зон ХХК /цаашид "Нийлүүлэгч" гэх/, түүнийг төлөөлж Тэргүүн дэд захирал Б.Цээсүрэн /хамтад нь "Талууд" гэх/ нар Монгол Улсын Иргэний тухай хуулийг удирдлага болгон ДҮТ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 03 дугаар сарын 02-ний өдрийн А/40 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хорооны 2020 оны 09-р сарын 01-ний өдөр Захиалагчид ирүүлсэн "ШИЙДВЭР №5"-ийг үндэслэн Талууд дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэ ГЭРЭЭГ байгуулав.


1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэ гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь энэ гэрээний хавсралтад заасан "Сүлжээний тоног төхөөрөмж, лиценз худалдан авах /Багц-2/: Багц-2 Сүлжээний хамгаалалтын CiscoFirePower 2120 security appliance түүнтэй дүйцэхүйц, түүний лиценз худалдан авах" тендер (цаашид "Бараа" гэх)-ийг **52,881,400 /тавин хоёр сая найман зуун наян нэгэн мянга дөрвөн зуун/** төгрөг /цаашид "Гэрээний үнэ" гэх)-өөр нийлүүлэхээр ирүүлсэн Нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийн **52,881,400 /тавин хоёр сая найман зуун наян нэгэн мянга дөрвөн зуун/** төгрөг /энэ үнэд НӨАТ орсон/-ийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь "Сүлжээний тоног төхөөрөмж, лиценз худалдан авах /Багц-2/: Багц-2 Сүлжээний хамгаалалтын CiscoFirePower 2120 security appliance түүнтэй дүйцэхүйц, түүний лиценз худалдан авах" тендерийн гүйцэтгэлийг гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 45 хоногт бүрэн нийлүүлж хүлээлгэн өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:
  - Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - Үнийн санал;
  - Гэрээний ерөнхий нөхцөл;
  - Гэрээний тусгай нөхцөл;
  - Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
6. Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.
7. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэ гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
8. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.


9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:****ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ЕРӨНХИЙ ДИСПЕТЧЕР

 /Б.БААТАР/  
АСЭ ДЭД ЗАХИРАЛ


 /С.БҮРЭНТОГТОХ/  
ЗУА-ИЙН ДАРГА

 /Б.БИНДЭРЪЯА/  
СУАА-НИЙ ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ  
НЯГТЛАН БОДЛОГЧ

 /А.ЦАГААНСАР/  
ИМТА-НЫ ДАРГА

 /Б.ДАВААНЯМ/  
ЗУА-НЫ ХУДАЛДАН АВАЛТ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН

 /Э.ӨЛЗИЙМАНДАХ/  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

 /С.НАМЧИНДОРЖ/ - 2

**ХАЯГ:**

Монгол Улс, Улаанбаатар хот 17060 Хан-  
уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн Өргөн  
чөлөө Засгийн газрын XIV байр 4,5 давхар  
Утас: 7004 1371  
Факс: 7004 3467

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ГЭРЭЭ ХАРИУЦСАН МЕНЕЖЕР

 /Д.БАТХОЛБОО/  


**ХАЯГ:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар  
дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай-5,  
Сити Тауэр, 4-р давхар, 403 тоот  
Утас: +976 77317731, 77312424  
РД: 2113155  
Банк: ХХБ  
Данс: 499026123



АЙ ТИ ЗОН ХХК-Д

**ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ**

ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ  
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

17060 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,  
3-дугаар хороо, Засгийн газрын XIV байр  
Утас: 7004-1315, Факс: (976) 7004-3467  
E-mail: ndc@ndc.energy.mn

2020 09 04 № 01/1176  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 29 дэх заалт, гүйцэтгэх захирлын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/40 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо хуулийн 14-16 заалтуудын шаардлагыг хангасан тухай 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дүгнэлтийг үндэслэн "Сүлжээний тоног төхөөрөмж, лиценз худалдан авах /2 багц/" бараа нийлүүлэх тендерийн дахин зарлагдсан Багц №2 буюу "Сүлжээний хамгаалалтын төхөөрөмж CiscoFirePower 2120 security appliance түүнтэй дүйцэхүйц, түүний лиценз худалдан авах" Багц №2-т "хамгийн сайн" гэж үнэлэгдсэн тул 29.2 дахь заалтын дагуу гэрээ байгуулах эрх олгож байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Г.БАЛЖИННЯМ

00000000

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Нэр томъёо 1.1. Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
- (а) "гэрээ" гэж захиалагч, нийлүүлэгчийн хооронд байгуулсан бараа нийлүүлэх гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.
  - (б) "гэрээний үнэ" гэж гэрээний дагуу гэрээний үүргээ бүрэн болон зохих хэмжээнд гүйцэтгэсний дагуу нийлүүлэгчид төлөх үнийг хэлнэ.
  - (в) "бараа" гэж нийлүүлэгчээс захиалагчид гэрээний дагуу нийлүүлэх тоног төхөөрөмж, машин механизм болон бусад материалыг хэлнэ.
  - (г) "бусадүйлчилгээ" гэж тээвэрлэлт, даатгал болон бусад дагалдах үйлчилгээ, угсралт, техникийн туслалцаа, сургалт зэрэг гэрээний дагуу нийлүүлэгчийн үзүүлэх аливаа дагалдах ажил, үйлчилгээ, үүргийг хэлнэ.
  - (д) "захиалагч" гэж барааг худалдан авч буй гэрээний тусгай нөхцөлд нэрлэсэн байгууллагыг хэлнэ.
  - (е) "нийлүүлэгч" гэж гэрээнд заасан бараа, үйлчилгээг нийлүүлж буй этгээдийг хэлнэ.
  - (ж) "ажлын талбай" гэж гэрээний тусгай нөхцөлд тодорхойлсон газрыг хэлнэ.
  - (з) "хоног" гэж хуанлийн хоногийг хэлнэ.
2. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах, хяналт шалгалт явуулах
- 2.1. Нийлүүлэгч нь захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд гэрээ ба түүний нөхцөл, эдгээртэй холбогдуулж захиалагчийн өгсөн техникийн тодорхойлолт, зураг, загвар, дээж зэрэг мэдээллийг гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтнаас бусад этгээдэд задлаж болохгүй. Гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтныг зөвхөн түүний хариуцсан ажилд шаардлагатай мэдээллээр хангана.
- 2.2. Захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд, нийлүүлэгч 2.1-т дурдсан баримт бичиг болон мэдээллийг гэрээ гүйцэтгэхээс бусад зорилгоор ашиглахгүй.
- 2.3. 2.1-т дурдсан гэрээнээс бусад баримт бичиг захиалагчийн өмч хэвээр үлдэх ба хэрэв захиалагч хүсвэл нийлүүлэгч гэрээний үүргээ гүйцэтгэж дуусмагц (бүх хувийг) захиалагчид буцааж өгнө.
- 2.4. Захиалагч нийлүүлэгчийн гэрээний гүйцэтгэлд хамаарах данс, бүртгэлийг шалгах эрхтэй ба аудитор томилж эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийлгэх эрхтэй.
3. Захиалгыг өөрчлөх
- 3.1. Захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээний ерөнхий цар хүрээнд багтаан дор дурдсан нэг буюу түүнээс дээш зүйлийн захиалгыг хэдийд ч өөрчлөх эрхтэй. Үүнд:
- (а) гэрээний дагуу нийлүүлэгдэх барааг захиалагчид зориулан тусгайлан үйлдвэрлэсэн байхаар зураг, зураг төсөл, техникийн тодорхойлолтыг өөрчлөх;

(б) тээвэрлэлтийн болон баглаа боодлын хэлбэр;

(в) барааг хүргэх газар.

- 3.2. Нийлүүлэгч нь захиалгын өөрчлөлтийн (цаашид "өөрчлөлт" гэх) улмаас гэрээнд заасан бараа нийлүүлэх хугацаанд үзүүлэх нөлөөг (хэрэв нөлөөлөх бол) харгалзан түүний зардлын нарийвчилсан тооцоо, хэрэгжүүлэх хуваарийг гаргаж, өөрчлөлтийн мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор захиалагчид танилцуулна.
- 3.3. Захиалагч 3.2-т дурдсан нийлүүлэгчийн тооцоог үндэслэж өөрчлөлтийг бичгээр батлах ба ийнхүү баталгаажуулах хүртэл нийлүүлэгч 3.1-д дурдсан өөрчлөлтийг гүйцэтгэхгүй.
- 3.4. Харилцан тохиролцсон өөрчлөлт нь гэрээний хэсэг болох ба энэ өөрчлөлтөд гэрээний нөхцөл, болзол үйлчилнэ.
4. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах
- 4.1. Энэхүү гэрээний 3 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд гэрээний нөхцөл, болзлыг засварлах, эсхүл өөрчилж болохгүй. Зайлшгүй шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж талууд гарын үсэг зурна.
5. Туслан гүйцэтгэх гэрээ байгуулах
- 5.1. Захиалагч урьдчилж бичгээр зөвшөөрөөгүй тохиолдол нийлүүлэгч гэрээ болон түүний аль нэг хэсгийг туслан гүйцэтгүүлэх зорилгоор туслан гүйцэтгэгч сонгож түүнтэй гэрээ байгуулж болохгүй.
- 5.2. Нийлүүлэгч гэрээг хэрэгжүүлэхдээ сонгосон аливаа туслан гүйцэтгэгч нь өөрийн хариуцсан ажил үүрэгт ногдох гэрээний холбогдох нөхцөл, болзлыг бүрэн биелүүлэхийг батламжилна.
6. Барааны гарал үүслийн улс
- 6.1. Гэрээний дагуу нийлүүлэх бараа нь аль ч улсаас гарал үүсэлтэй байж болно.
- 6.2. Барааны гарал үүслийн улс гэдэгт барааг олборлосон, ургуулсан, бойжуулсан, эсхүл хийж бүтээсэн газрыг хэлнэ. Хийж бүтээсэн гэж үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.
7. Шалгалт болон туршилт
- 7.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй. Гэрээний тусгай нөхцөлд эсвэл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. Захиалагч шалгалт, туршилт хийхээр томилсон төлөөлөгч(дийг) нийлүүлэгчид бичгээр мэдэгдэнэ.
- 7.2. Шалгалт, туршилтыг нийлүүлэгчийн, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн эзэмшил газар, барааг хүргэх газар болон эцсийн цэгт явуулж болно. Шалгалт, туршилтыг нийлүүлэгчийн, эсхүл түүний туслан гүйцэтгэгчийн эзэмшил газар явуулсан тохиолдолд захиалагчийг шаардлагатай байгууламж, зураг, үйлдвэрлэлийн өгөгдөл болон бусад туслалцаагаар үнэ төлбөргүй хангана.

- 7.3. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна.
- 7.4. Барааг тээвэрлэхээс өмнө захиалагч, эсхүл түүний төлөөлөгч шалгасан, туршсан байх нь Монгол Улсад орж ирсний дараа түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд татгалзаж болох захиалагчийн эрхийг хөндөхгүй.
- 7.5. Энэ зүйлийн аль ч нөхцөл, болзол нийлүүлэгчийг гэрээний баталгаат засварын болон бусад үүргээс чөлөөлөхгүй.
8. **Баглаа боодол**
- 8.1. Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудахаас урьдчилан сэргийлэх баглаа боодлоор гэрээнд заасны дагуу хангана. Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн хатуу нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн болон давс, хур тундас зэргийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгохдоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, түүнчлэн тээвэрлэлтийн цэг бүрт ачих, буулгах хангалттай төхөөрөмж байгаа эсэх зэрэг хүчин зүйлийг харгалзсан байна.
- 8.2. Баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичигийг бэлтгэхдээ гэрээнд, нэн ялангуяа гэрээний тусгай нөхцөлд заасан шаардлага болон захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг чанд мөрдөнө.
9. **Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт**
- 9.1. Нийлүүлэгч техникийн тодорхойлолтын шаардлагын дагуу барааг нийлүүлнэ. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулга, хувилбарыг хэрэглэнэ. Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан бол түүний дагуу тээврийн болон бусад бичиг баримтыг бэлтгэж бүрдүүлнэ.
- 9.2. Гэрээнд хэрэглэсэн CIF /СИП/, EXW /ИКСБ/, FOB /ФОБ/, FCA/ФСА/, CIF /СИФ/ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
10. **Зохиогчийн болон оюуны өмчийн эрх**
- 10.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглах явцад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн тохиолдолд гомдлыг нийлүүлэгч барагдуулж холбогдон гарах зардлыг хариуцна.
11. **Гүйцэтгэлийн баталгаа**
- 11.1. Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан мөнгөн дүн бүхий гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор захиалагчид өгнө.
- 11.2. Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэж чадаагүйгээс захиалагчид учрах хохирлыг нөхөж барагдуулахад уг баталгаа зориулагдана. Гэрээний гүйцэтгэлийг ГЕН-ийн 16.2-ын дагуу сунгахад нийлүүлэгч мөн хугацаагаар гүйцэтгэлийн баталгааны хүчинтэй хугацааг сунгана.

- 11.3. Гүйцэтгэлийн баталгаа нь ТӨӨЗ-ны 16 дугаар зүйлд заасан валютаар гаргасан банкны баталгаа, Засгийн газрын бонд эсхүл Засгийн газрын хүлээн зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр гаргасан баталгаа байна.
- 11.4. Нийлүүлэгч гэрээний дагуу гүйцэтгэх ажлыг дуусгавар болгосноос хойш 30 хоногийн дотор захиалагч гүйцэтгэлийн баталгааг хүчингүй болгоно.
- 12. Даатгал**
- 12.1. ГТН-д тусгайлан өөрөөр заагаагүй бол барааг үйлдвэрлэх, худалдаж авах, тээвэрлэх, нийлүүлэх, хадгалах, болон хүргэх үед гарч болох алдагдал, гэмтэлтэй холбоотой эрсдэлээс хамгаалж бүх барааг ГТН-д заасан хэлбэрээр инкотермсийн нөхцөлийн дагуу даатгуулна.
- 13. Чанарын баталгаа, баталгаа т засвар**
- 13.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь шинэ, урьд өмнө ашиглагдаагүй, гэмтэл согоггүй бөгөөд хамгийн сүүлийн буюу өнөөгийн загварын, техникийн тодорхойлолтод бүрэн нийцсэн орчин үеийн шинэлэг ололтуудыг агуулсан байна. Өөрийн болон туслан гүйцэтгэгчийн бараа нийлүүлэхэд ашиглах бүх материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл зэрэг нь шинэ, сайн чанарын болон зориулалтынх байна гэдгийг нийлүүлэгч баталгаажуулна.
- 13.2. ГТН-д өөрөөр заагаагүй бол баталгаат засвар нь барааг хүргэж, ашиглалтад хүлээлгэн өгснөөс хойш 12 сар, эсхүл барааны гарал үүслийн улсын боомтоос ачсан өдрөөс хойш 18 сар гэсэн хугацааны аль эрт дуусах хугацаанд хүчинтэй байна.
- 13.3. Захиалагч энэхүү баталгаатай холбогдох гомдлыг нийлүүлэгчид бичгээр шуурхай мэдэгдэнэ.
- 13.4. Нийлүүлэгч энэхүү мэдэгдлийг хүлээн аваад гэмтэл согогтой бараа, эсхүл түүний эд ангийг үнэ төлбөргүй, шуурхай засварлах буюу солино.
- 13.5. Захиалагч нь 13.2 заасныг үл харгалзан, 13.4-т заасны дагуу гэмтэл согогийг арилгаснаас хойш 12 сарын дотор засварласан бараанд энэ төрлийн гэмтэл согог дахин гарсан тухай бичгээр мэдэгдэл ирвэл уг гэмтэл согогийг үнэ төлбөргүй шуурхай арилгана.
- 13.6. Хэрэв нийлүүлэгч гэмтэл согог гарсан мэдэгдэл хүлээн аваад гэрээний дагуу түүнийг арилгахгүй бол захиалагч өөрөө нийлүүлэгчийн зардлаар уг гэмтэл согогийг арилгах эрхтэй. Энэ зүйлд заасны дагуу нийлүүлэгчийн гаргах баталгаа нь гэрээнд заасан захиалагчийн бусад эрх, үйл ажиллагааг хязгаарлахгүй.
- 14. Төлбөр**
- 14.1. Гэрээний дагуу нийлүүлэгчид төлөх төлбөрийн хэлбэр, нөхцөлийг ГТН-д дурдана.
- 14.2. Нийлүүлэгч нь гэрээний үүргээ бүрэн биелүүлсний дараагаар төлбөр хийхийг хүссэн хүсэлтийг төлбөрийн нэхэмжлэх болон ГЕН-ийн 9 дүгээр зүйлд заасан баримт бичгийн хамт захиалагчид хүргүүлнэ.
- 14.3. ГТН-д өөрөөр заагаагүй бол захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шуурхай хийнэ.
- 14.4. Гэрээний дагуу нийлүүлэгчид хийх төлбөрийг тендерийн маягтад дурдсан валютаар хийнэ.



15. Үнэ 15.1. Гэрээний дагуу хүргэсэн бараа болон гүйцэтгэсэн үйлчилгээний үнийг нэхэмжлэхдээ нийлүүлэгч өөрийн тендерт санал болгосон үнийг баримтлана. ГТН-ийн үнэ тохируулах нөхцөлийн дагуу үнийг тохируулах, эсхүл ГЕН-ийн 3 дугаар зүйлийн дагуу захиалгыг өөрчлөхөд тендерт санал болгосон үнэ өөрчлөгдвөл, өөрчлөгдсөн үнийг баримтлана.
16. Хуваарийг сунгах 16.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
- 16.2. Нийлүүлэгч дараах тохиолдолд бараа нийлүүлэлтийн хуваарийг сунгах тухай хүсэлт гаргаж болно. Үүнд:
- (а) захиалагч ГЕН-ийн 3 дугаар зүйлд заасны дагуу захиалгыг өөрчилсөн;
  - (б) захиалагчаас гаргаж өгөх материал, зураг, эсхүл үйлчилгээ хугацаа хоцорсон (үйлчилгээ гэдэгт гэрээний дагуу захиалагчийн гаргах зөвшөөрөл, баталгаа орно);
  - (в) ГЕН-ийн 22 дугаар зүйлд заасан гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүсвэл;
  - (г) захиалагчийн өгсөн захиалгаас шалтгаалан ажлын гүйцэтгэл хойшилсон.
- Нийлүүлэгч хугацаа хоцрохоос урьдчилан сэргийлэхийн тулд бололцоотой бүхнийг хийсэн гэдгийг захиалагчид нотлон харуулах үүрэгтэй. Хугацаа хоцролтын шалтгааныг арилгах, даван туулах арга замуудыг талууд хэлэлцэнэ.
- 16.3. Гүйцэтгэгч 16.2-т заасан нөхцөл байдал бий болсны улмаас бараа нийлүүлэлтийн хуваарь ямар нэг байдлаар хоцорч болох тухай захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдээгүй, эдгээр нөхцөл байдал бий болсныг нотлон харуулаагүй тохиолдолд 16.2-ыг үл харгалзах ба хуваарийг сунгахгүй.
17. Алданги оногдуулах 17.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг уг хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэх ёсгүй. Дээд хэмжээнд хүрсэн тохиолдолд захиалагч ГЕН-ийн 18 дугаар зүйлийн дагуу цуцлах тухай асуудлыг хөндөж болно.
18. Үүргээ биелүүлээгүй - гэс гэрээг цуцлах 18.1. Захиалагч дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүссэн тохиолдолд гэрээний дагуу зөрчлийг арилгах бусад арга хэрэгслийг ашиглалгүйгээр нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. Үүнд:
- (а) нийлүүлэгч аль нэг болон бүх барааг гэрээнд заасан эсвэл ГЕН-ийн 16 дугаар зүйлийн дагуу сунгасан хугацаанд хүргэж чадаагүй;
  - (б) нийлүүлэгчийн ирүүлсэн бараа нь техникийн тодорхойлолтын шаарлага хангаагүй бөгөөд гэрээний бусад үүргээ биелүүлээгүй;
  - (в) нийлүүлэгч 18.1.(а), 18.1.(б)-д заасан нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг захиалагчаас хүлээн аваад 10 хоногийн дотор (захиалагч үүнээс урт хугацаа заах эрхтэй) алдаагаа залруулаагүй;

- (г) нийлүүлэгч тендер шалгаруулалтад оролцох, гэрээ байгуулах, хэрэгжүүлэхдээ авлигал, залилан мэхлэх зохиомол тохиролцоо хийх болон айлган сүрдүүлэх үйлдэлд холбогдсоныг шүүх, эсхүл эрх бүхий байгууллага тогтоосон бол захиалагч түүнд гэрээ байгуулах эрх олгохгүй бөгөөд нэгэнт гэрээ байгуулах эрх олгогдсон, эсхүл гэрээ байгуулагдсан бол түүнийг цуцална.
- 18.2. 18.1-ийн дагуу гэрээг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн цуцалсан тохиолдолд захиалагч нийлүүлэгдээгүй барааг тохиромжтой гэж үзсэн нөхцөлөөр захиалагч худалдан авах эрхтэй ба үүнтэй холбогдон гарсан нэмэлт зардлыг нийлүүлэгч хариуцна. Энэ зүйлийг үл харгалзан нийлүүлэгч гэрээний цуцлагдаагүй хэсгийг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.
19. Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах
- 19.1. Нийлүүлэгч дамлуурах, эсхүл бусад хэлбэрээр төлбөрийн чадваргүй болсон бол захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг хэдийд ч цуцлах эрхтэй. Ингэхдээ захиалагч нийлүүлэгчид учирсан хохирлыг нөхөн төлөхгүй. Гэвч ийнхүү цуцалсан нь захиалагчид үүссэн эсвэл ирээдүйд үүсэх аливаа эрхийг, хөндөхгүй.
20. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах
- 20.1. Захиалагч шаардлагатай тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдэж гэрээг хэдийд ч бүхэлд нь эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. <sup>10</sup>Захиалагч мэдэгдэлдээ өөрийн шаардлагаар гэрээг цуцлах болсон үндэслэл болон гэрээний аль хэсгийг, хэзээнээс цуцалж буйг заавал дурдана.
- 20.2. Мэдэгдэл нийлүүлэгчид очсоноос хойш 30 хоногийн дотор тээвэрлэхэд бэлэн болсон барааг захиалагч гэрээнд заасан үнэ болон бусад нөхцөлөөр худалдаж авна. Үлдэх барааны хувьд захиалагч дор дурдсан сонголтын аль нэгийг, эсхүл хоёуланг хэрэгжүүлнэ. Үүнд:
- (а) үлдэх барааны одоогоор бэлэн болсон аливаа хэсгийг гэрээнд заасан үнэ, бусад нөхцөлөөр авах, болон/эсхүл
- (б) үлдэх барааг цуцлах ба нийлүүлэгчийн хагас бэлэн болсон бараа, гэрээг хэрэгжүүлэх зорилгоор худалдаж авсан материал, эд ангийн хэлэлцэж тохирсон үнийг төлнө. Энэ дүнд захиргааны зардлын болон ашгийн зохих хэмжээг оруулж тооцно.
21. Маргааныг шийдвэрлэх
- 21.1. Захиалагч болон нийлүүлэгчийн хооронд гэрээтэй холбогдож гарч болох маргааныг зөвшилцөл болон албан бус хэлэлцээрээр шийдэхийг хичээнэ.
- 21.2. Дээрх хэлэлцээр 30 хоног үргэлжлэхэд гэрээний маргааныг талууд шийдэж чадахгүй бол аль ч тал ГТН-д заасны дагуу шүүхэд хандах эрхтэй.
22. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал
- 22.1. Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэнээс захиалагч, эсхүл нийлүүлэгч, эсхүл туслан гүйцэтгэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаа хоцорсон бол ГЕН-ийн 16 дугаар зүйлийн дагуу түүнийг гүйцэтгэх хугацааг сунгана.

- 22.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол нийлүүлэгч гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.
23. Гэрээний үүргийг шилжүүлэх
- 23.1. Ямарч тохиолдолд гэрээний үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
24. Гэрээнд ашиглах хэл
- 24.1. Нийлүүлэгч ГТН-д заасан гэрээнд ашиглах хэлийг бүрэн ойлгох мэдлэгтэй гэдгээ үүгээр баталж байна. Гэрээ түүнд холбогдох баримт бичиг, харилцах бичиг баримт нь энэ хэл дээр байна.
- 24.2. 24.1-д заасан хэл рүү орчуулах зардал болон орчуулгын үнэн зөвийг нийлүүлэгч хариуцна.
25. Татвар болон хураамж
- 25.1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна оногдуулдаг бүх төрлийн татвар, хураамжийг нийлүүлэгч бүрэн хариуцна.
26. Гарчиг
- 26.1. Гэрээний бүлэг, зүйл болон бусад хэсгийн гарчиг нь зөвхөн тайлбарын шинжтэй бөгөөд гэрээний хэсэг болохгүй.
27. Үүргийн гүйцэтгэл
- 27.1. Аль нэг тал нь гэрээний үүргээ гүйцэтгэхийг хатуу шаардаагүй нь нөгөө талын уг үүргийг биелүүлэхгүй байх шалтгаан болохгүй.
-

ДОЛООДУГААР БҮЛЭГ  
ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

Гэрээний тусгай нөхцөлийг бэлтгэх санамж

Гэрээний ерөнхий нөхцөлд дурдсан захиалагч, бараа зэрэг нэр томъёо тухайн гэрээнд юуг илэрхийлэхийг гэрээний тусгай нөхцөлд заадаг. Гэрээний тусгай нөхцөлийг бэлтгэхдээ дараах зүйлсийг шалгана. Үүнд:

1. Гэрээний ерөнхий нөхцөлийн аль нэг зүйлд гэрээний тусгай нөхцөлийг ишилсэн бол холбогдох нөхцөлийг гэрээний тусгай нөхцөлд заавал оруулна.
2. Тухайн гэрээний шаардлагаар гэрээний ерөнхий нөхцөлийг засварлах, илүү дэлгэрүүлэх тохиолдолд эдгээрийг гэрээний ерөнхий нөхцөлд бус тусгай нөхцөлд тусгана.
3. Гэрээний ерөнхий нөхцөл (ГЕН) болон гэрээний тусгай нөхцөл (ГТН) хоорондоо зөрчилдсөн тохиолдолд гэрээний тусгай нөхцөлийг баримтлана. Гэрээний ерөнхий нөхцөлийн холбогдох зүйлийн дугаарыг хаалтад хийж ишлэв.
4. ГТН-ийг хэрхэн бэлтгэх тухай зааврыг [ ] дөрвөлжин хаалтанд бичив. Зарим жишээ нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч боловсруулна.

ДОЛООДУГААР БҮЛЭГ  
ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Тодорхойл олт (ГЕН - 1)	1.1.(д)	Захиалагч нь <i>Диспетчерийн Үндэсний Төв ХХК</i>
	1.1 (ж)	Ажлын талбай нь <i>Техникийн нөхцөлд тусгасанаар</i>
2. Шалгалт туршилт (ГЕН - 7)	7.0	<i>Техникийн нөхцөлд тусгасанаар</i>
3. Баглаа боодол (ГЕН - 8)	8.0	<i>Тухайн тоног төхөөрөмж нь үйлдвэрлэлийн лац, савлагаатай шинэ байх бөгөөд зориулалтын дагуу тээвэрлэнэ.</i>
4. Барааг хүргэх болон бичиг баримтын бүрдүүлэлт (ГЕН - 9)	9.0	<i>ГЕН-ийн 9 дүгээр зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ.</i>
	9.3	<p><i>"Монгол Улсын гаднаас санал болгосон бараа (жишээлбэл СИП):</i></p> <p><i>Нийлүүлэгч барааг тээврийн хэрэгсэлд ачсаны дараа энэ тухай бүрэн мэдээллийг захиалагч болон даатгалын байгууллага утсан холбоогоор мэдэгдэнэ. Мэдэгдэлд гэрээний дугаар, барааны нэр, тоо ширхэг, тээврийн хэрэгслийн нэр, тээврийн баримтын дугаар, ачсан боомт, боомтоос гарах огноо, буулгах боомт зэргийг дурдана.</i></p> <p><i>Нийлүүлэгч дараах баримт бичгийг<sup>11</sup> захиалагч болон даатгалын байгууллагад шуудангаар илгээнэ:</i></p> <ol style="list-style-type: none"><li><i>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;</i></li><li><i>2) барааг бүрэн бүтэн усан онгоцонд ачуулсан болохыг гэрчлэх "Тээврийн хөлс урьдчилан төлөгдсөн" гэсэн тэмдэглэл бүхий бусдад шилжүүлж болох ачааны нэхэмжлэх (bill of lading)-ийн үндсэн болон [моо] ширхэг хуулбар хувийг бусдад үл шилжүүлэх ачааны нэхэмжлэхийн [моо] ширхэг хуулбар хувийн хамт;</i></li><li><i>3) барааны багц бүрийн баглаа боодлын жагсаалт;</i></li><li><i>4) даатгалын гэрчилгээ;</i></li><li><i>5) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;</i></li><li><i>6) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалт туршилтын гэрчилгээ;</i></li><li><i>7) барааны гарал үүслийн гэрчилгээ.</i><p><i>Энд жагсаасан бичиг баримтыг барааг хүргэх газар, эсхүл боомтод ирэхээс 7 хоногийн өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</i></p></li></ol>

9.4 Монгол Улсын дотроос санал болгосон бараа (ИКСБ):

- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
- 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
- 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
- 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
- 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс 7 хоногийн өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна."

- |  |      |  |
|--|------|--|
| 5. Гүйцэтгэлийн баталгаа (ГЕН - 11)            | 11.1 | "Ашиглахгүй"   |
| 6. Баталгаат засвар (ГЕН-13)                   | 13.0 | Баталгаат засварын тусгай шаардлага<br><br>Техникийн шаардлагын дагуу тоног төхөөрөмжид 1 жил, ажлын гүйцэтгэлд 1 жилийн баталгаа шаардлагатай.<br><br>Баталгааны хугацаанд тоног төхөөрөмжид үйлдвэрлэлийн механик бус гэмтэл гарсан тохиолдолд тус төхөөрөмжийг ижил тухайн маркийн шинэ төхөөрөмжөөр үнэ төлбөргүй сольж өгнө. Ашиглалтаас шалтгаалан механик гэмтэл гарсан тохиолдолд ТШӨХ-д заасан нөхцлөөр тендерийн материалд ирүүлсэн саналын дагуу богино хугацаанд засварлана. |
| 7. Төлбөр (ГЕН - 14)                           |      | ГЕН-ийн 14 дүгээр зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд: <sup>12</sup><br><br>Гэрээний үнийн дүнгийн <sup>100</sup> хувийг барааг хүлээн авсан, суурилуулалт хийсэн акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 9 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.  |
| 7. Үнэ (ГЕН - 15)                              | 15.1 | Гэрээний үнийн дүнд тохируулга хийхгүй тогтмол байна.  |
| 8. Алданги оногдуулах (ГЕН - 17) <sup>13</sup> | 17.1 | Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн [0.05] хувь байна. <sup>14</sup><br><br>Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн [10] хувь байна.   |

10. Маргааныг  
шийдвэрлэх  
(ГЕН - 21)

21.0

[ГЕН-ийн 21 дүгээр зүйлтэй уялдуулж ГТН-д шүүхийн байгууллагын тухай илүү дэлгэрэнгүй нөхцөлийг оруулна. Нийлүүлэгч Монгол Улсын хуулийн этгээд биш тохиолдолд олон улсын арбитрын байгууллагыг сонгож болно. Жишээлбэл, "Олон улсын худалдааны танхимын Арбитраж болон эвлэрлийн дүрмийн дагуу сонгогдсон арбитрын шүүгч энэ дүрмийн дагуу маргааныг шийдвэрлэнэ". Арбитрын байгууллага маргаан шийдвэрлэх ажиллагаа явагдах улсыг заах ба арбитрын байгууллагын шийдвэр эцсийнх бөгөөд талууд заавал биелүүлэх үүрэгтэй болохыг мөн заана.

Захиалагч 1976, эсхүл 1980 оны НҮБ-ын Худалдааны комиссын (UNCITRAL) арбитрын дүрэм, Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх олон улсын төвийн арбитрын болон эвлэрлийн дүрэм эсвэл тус төвийн маргааныг шийдэх бусад дүрэм гэх мэт маргааныг шийдэх ижил төрлийн дүрмийг сонгож болно.]

12. Даатгал

Гүйцэтгэгчийн хүлээх эрсдэлд хамаарах дор дурдсан тохиолдлын даатгалыг гүйцэтгэгч нь ажил эхлэх өдрөөс чанарын баталгаат хугацаа дуусах хүртэл хугацаанд гүйцэтгэгч, захиалагчийн хамтарсан нэрээр хийлгэнэ.

(а) ажил, байгууламж болон материал алдагдах, эвдэрч гэмтэх; (б) тоног төхөөрөмж алдагдах, эвдэрч гэмтэх;

(в) гэрээний хэрэгжилттэй холбогдож эд хөрөнгө (ажил, байгууламж, материал, тоног төхөөрөмжөөс бусад) алдагдах, эвдэрч гэмтэх;

(г) хүн бэртэх, эсхүл нас барах.

**ДООРХИ НӨХЦӨЛҮҮДИЙГ ШААРДЛАГАТАЙ  
ТОХИОЛДОЛД ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛД  
ЗААЖ ОРУУЛНА]**

Урамшуулал	[Гэрээгээр нийлүүлэгдэх барааг хуваариас өмнө хүргэх нь захиалагчид ашигтай бол барааг хуваариас өмнө хүргэсэн тохиолдолд нийлүүлэгчид мөнгөн урамшуулал өгөх тухай нөхцөлийг оруулж болно.]
Хохирлыг барагдуулах	[Тухайн барааны шинж чанарын улмаас ямар нэг алдагдлыг (жишээлбэл бүтээгдэхүүний хариуцлагатай холбогдсон) нөхөх, эсхүл үүрэг хүлээх шаардлага үүсч болзошгүй тохиолдолд энэ тухай заалтыг ГТН-д заана.]
Сэлбэг	[Энд боломжтой бол захиалагчид шаардлагатай сэлбэг, хэрэгслийн жагсаалтыг, эсхүл захиалагчийг шаардлагатай сэлбэг хэрэгслээр хангах зорилгоор тэдгээрийг үйлдвэрлэх, нийлүүлэхийг гүйцэтгэгч зөвшөөрөх тухай заалтыг оруулна. Сэлбэгээр хангах үүргийн үргэлжлэх хугацаа, сэлбэг авах тухай захиалагчийн хүсэлтийг нийлүүлэгч хүлээн аваад ямар хугацаанд нийлүүлэх тухай заана.]
Лиценз болон зөвшөөрөл	[Барааг импортлох болон ашиглахад ямар нэг лиценз, зөвшөөрөл шаардагдах бол тус лиценз, зөвшөөрлийг гаргуулах болон холбогдох зардлыг аль тал хариуцах тухай заалтыг оруулна.]
Албан бичиг солилцох	[Захиалагч гэрээний маягтын 4 дүгээр зүйлд заасан мэдэгдлээс бусад албан бичгийг өөр хаягаар хүлээн авах, илгээх хүсэлтэй бол үүнийгээ ГТН-д заана.]



## МОНГОЛ УЛСЫН ГАДНА ҮЙЛДВЭРЛЭГДСЭН БӨГӨӨДИМПОРТООР ОРЖ ИРЭХ БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ

Захиалагч байгууллагын нэр :

"Диспетчерийн Үйлэсний Төв" ХХК

Тендерт оролцогч байгууллагын нэр :

"Ай Ти Зон" ХХК

Огноо :

2020 оны 08-р сарын 27

НТШ-ын нэр, дугаар :  
 Сүлжээний тоног төхөөрөмж, лиценз худалдан авах, ДУТ/202001011  
 Багц-2 "Сүлжээний хамгаалалтын төхөөрөмж CiscoFirePower 2120 security appliance түүнтэй дүйсэхүйц, түүний лиценз худалдан авах"

Барааны нэр, төрөл/голорхойлолт	Гарал үүслийн улс	Тоо Ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ	Эцсийн цэгт хүргэх тээврийн зардалын нийт үнэ	Гэрээ байгуулсан тохиолдолд тогтож болох НОТ бусад албан татвар	Нийт дүн
Сүлжээ хамгаалалтын төхөөрөмж Cisco FPR2120-NGFW-K9 Сүлжээ хамгаалалтын төхөөрөмж лиценз L-FPR2120T-TMC-IU9, CON-SNT-FP21GFN	Хонгконг	1	47,146,900₮	47,146,900₮	Эцсийн цэгт хүргэх тээврийн зардалын нийт үнэ багтсан	4,714,690₮	51,861,590₮
	Хонгконг	1	927,100₮	927,100₮	Эцсийн цэгт хүргэх тээврийн зардалын нийт үнэ багтсан	92,710₮	1,019,810₮
<b>Тендерийн нийт дүн</b>							<b>52,881,400₮</b>

Тендерт оролцогчийн нэр :

"Ай Ти Зон" ХХК

Тендерт оролцогчийн эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, нэр :

Б.Цэсэрэн

Албан тушаал :

Төргүүн дэд захирагч

Огноо :

2020.08.27



## Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь

Захиалагч байгууллагын нэр :

"Диспетчерийн Үндэсний Төв" ХХК

Тендерт оролцогч байгууллагын нэр :

"Ай Ти Зон" ХХК

Огноо :

2020 оны 08-р сарын 27

НТШ-ын нэр, дугаар :

Сүлжээний тоног тохөөрөмж, лиценз худалдан авах, ДУТ/202001011  
Багц-2 "Сүлжээний хамгаалалтын төхөөрөмж CiscoFirePower 2120 security appliance түүнтэй дүйнхүүин, түүний лиценз худалдан авах"

Барааны нэр, торол/тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТНӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Илгээгчийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
				Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
Сүлжээ хамгаалалтын төхөөрөмж Cisco FPR2120-NGFW-K9	1	ширхэг	Гэрээнд заасан хаягаар хүргэнэ	Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 45 хоног	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 45 хоног
Сүлжээ хамгаалалтын төхөөрөмж лиценз L-FPR2120T-TMC-1Y9, CON-SNT-FP21GFN	1	ширхэг	Гэрээнд заасан хаягаар хүргэнэ	Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 45 хоног	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 45 хоног

Тендерт оролцогчийн нэр :

"Ай Ти Зон" ХХК

Тендерт оролцогчийн эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, нэр :

Б.Цэвэрэн

Албан тушаал :

Тэрүүн гэд захирал

Огноо :

2020.08.27



**Барааны техникийн тодорхойлолтын харьцуулалт**

Захиалагч байгууллагын нэр :	Диспетчерийн үндэсний төв
Тендерт оролцогч байгууллагын нэр :	Ай Ти Зон ХХК
Огноо :	2020 оны 08 сарын 27
НТШ-ын нэр, дугаар :	Сүлжээний тоног төхөөрөмж, лиценз худалдан авах, ДҮТ/202001011 Багц-2 “Сүлжээний хамгаалалтын төхөөрөмж CiscoFirePower 2120 security appliance түүнтэй дүйцэхүйц, түүний лиценз худалдан авах”

Д/д	Тавигдах шаардлага	Тавигдах шаардлага	Тавьсан шаардлагад нийцсэн эсэх
	Техникийн үзүүлэлт, тодорхойлолт	Техникийн үзүүлэлт, тодорхойлолт	
	<b>Доорх үзүүлэлттэй дүйцэхүйц</b>	<b>Доорх үзүүлэлттэй дүйцнэ</b>	
	<b>1. Сүлжээ хамгаалалтын төхөөрөмж: Cisco FirePower 2120 дүйцэхүйц</b>	<b>Cisco FPR2120-NGFW-K9</b>	Нийцнэ
	Загвар: FirePower 2120 болон түүнтэй дүйцэхүйц	Загвар: FirePower 2120	Нийцнэ
	Үйлдвэрлэгч: Cisco болон түүнтэй дүйцэхүйц	Үйлдвэрлэгч: Cisco	Нийцнэ
	Throughput: FW + AVC: 3 Gbps болон түүнээс дээш	Throughput: FW + AVC: 3 Gbps	Нийцнэ
	Throughput: AVC + IPS: 3 Gbps болон түүнээс дээш	Throughput: AVC + IPS: 3 Gbps	Нийцнэ
	Maximum concurrent sessions, with AVC: 1.2 mil болон түүнээс дээш	Maximum concurrent sessions, with AVC: 1.2 million	Нийцнэ
	Maximum new connections per second, with AVC: 16,000	Maximum new connections per second, with AVC: 16,000	Нийцнэ
	IPSec VPN Throughput: 1 Gbps	IPSec VPN Throughput: 1 Gbps	Нийцнэ
	Dimensions: 1 unit	Dimensions: 1 unit	Нийцнэ
2	Integrated I/O: 12 x 10M/100M/1GBASE-T Ethernet interfaces (RJ-45), 4 x 1 Gigabit (SFP) Ethernet interfaces	Integrated I/O: 12 x 10M/100M/1GBASE-T Ethernet interfaces (RJ-45), 4 x 1 Gigabit (SFP) Ethernet interfaces	Нийцнэ
	Maximum number of interfaces: Up to 16 total Ethernet ports (12x1G RJ-45, 4x1G SFP)	Maximum number of interfaces: Up to 16 total Ethernet ports (12x1G RJ-45, 4x1G SFP)	Нийцнэ
	Integrated network management ports: 1 x 10M/100M/1GBASE-T Ethernet port (RJ-45)	Integrated network management ports: 1 x 10M/100M/1GBASE-T Ethernet port (RJ-45)	Нийцнэ
	Serial port: 1 x RJ-45 console	Serial port: 1 x RJ-45 console	Нийцнэ
	Storage: 1x 100 GB, 1x spare slot (for MSP)	Storage: 1x 100 GB, 1x spare slot (for MSP)	Нийцнэ
	Threat protection: DDos attack, fragmented and malformed packets, blended threats	Threat protection: DDos attack, fragmented and malformed packets, blended threats	Нийцнэ
	User interface: Centralized console, Web UI	User interface: Centralized console, Web UI	Нийцнэ
	Ашиглалт: Шинэ байх	Ашиглалт: хэрэглэгчийн захиалгаар үйлдвэрлэнэ	Нийцнэ
	Бусад: 1-2 ажилтанд админы сургалт явуулах	Бусад: 1-2 ажилтанд админы сургалтанд хамруулна.	Нийцнэ
	Дээрх техникийн үзүүлэлтэд шаардагдах лиценз 1 /нэг/ ширхэг	Дээрх техникийн үзүүлэлтэд шаардагдах лиценз 1 /нэг/ ширхэг	Нийцнэ

	<p>L-FPR2120T-TMC-1Y</p> <ul style="list-style-type: none"> <li>• Cisco FPR2120 Threat Defence Threat, Malware and URL 1Y Subs- болон түүнээс дээш</li> <li>• 1 жил болон түүнээс дээш халдлага илрүүлэх лиценз</li> </ul>	<p>L-FPR2120T-TMC-1Y</p> <ul style="list-style-type: none"> <li>• Cisco FPR2120 Threat Defence Threat, Malware and URL 1Y Subs- болон түүнээс дээш</li> <li>• 1 жил болон түүнээс дээш халдлага илрүүлэх лиценз</li> </ul>	<p>Нийцнэ</p> <p>Нийцнэ</p>
	<p>CON-SNT-FPR21GFN</p> <ul style="list-style-type: none"> <li>• SNTC-8X5XNBD –Cisco Firepower 2120 NGFW Appliance, 1U</li> <li>• 1 жилийн үнэ төлбөргүй техникийн тусламж үйлчилгээ</li> </ul>	<p>CON-SNT-FPR21GFN</p> <ul style="list-style-type: none"> <li>• SNTC-8X5XNBD –Cisco Firepower 2120 NGFW Appliance, 1U</li> <li>• 1 жилийн үнэ төлбөргүй техникийн тусламж үйлчилгээ багтсан.</li> </ul>	<p>Нийцнэ</p>

Тендерт оролцогчийн нэр :  
Тендерт оролцогчийн эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, нэр :

Албан тушаал :

Огноо :



"Ай Ти Зон" ХХК

Б.Цэвсүрэн

Дэд захирал  
2020.08.27